

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
А.ТҮВШИНЗАЯАГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. Стратегийн зорилт 7. “Хөгжлийн бодлогын баримт бичиг, салбарын стратегийн төлөвлөгөө, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт хэрэгжилтэд аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зөвлөмж өгөх” Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт 3. “Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах зөвлөмжийн биелэлт хангасан эсэхэд хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчид тайлагнах”							
1.	Арга хэмжээ 1.1. Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, www.new.unelgee.gov.mn цахим хаягт оруулсан байх.	Цаасан суурьтай хүргүүлсэн баримт бичгийн тоо, www.new.unelgee.gov.mn цахим системд тайлагнасан тоо	Биелэлтийн тайланг 2024.07.05-ны өдрийн 03/1396, дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. 2024 онд системд нийт 15 удаа тайлагнасан.	1 6	2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн биелэлтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/1291 дугаартай албан бичгээр илгээсэн. Түүнчлэн цахим системд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш 4 удаа цахим системд тайлан оруулсан. Мөн Засгийн газрын 2025 он 43 дугаар тогтоолоор уг тайланг улиралд 1 удаа цахим системээр тайлагнах эрх зүйн зохицуулалттай болсон. Түүнчлэн хагас бүтэн жилээр тайланг цаасан хэлбэрээр илгээхээр байна. Өөрөөр хэлбэл журмын дагуу жилд 4 удаа тайлагнахаар болсон.	2025/01 2025/12	100%
2.	Арга хэмжээ 1.2. "Шинэ сэргэлтийн бодлого"-ын	Гарсан тайлан,	2024 оны 07 дугаар сарын 31-	-	Сүүлийн хагас жилд төлөвлөсөн.	2025/08	Хугацаа

	хэрэгжилтийн биелэлтэд, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байх, www.new.unelgee.gov.mn цахим хаягт оруулан баталгаажуулсан байх.	хяналт-шинжилгээ үнэлгээний дүгнэлт зөвлөмжийн хамт холбогдох байгууллагад хүргүүлсэн албан бичгийн тоо	ний өдрийн 03/53 дугаартай албан бичгээр “Шинэ сэргэлтийн бодлого”-ын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлсэн				болоог үй
3.	Арга хэмжээ 1.3. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, холбогдох байгууллагад хүргүүлсэн байх, www.new.unelgee.gov.mn цахим хаягт оруулан баталгаажуулсан байх.	Гарсан тайлан, хяналт-шинжилгээ үнэлгээний дүгнэлт зөвлөмжийн хамт холбогдох байгууллагад хүргүүлсэн албан бичгийн тоо	2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/2718 албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	1	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан 3 зорилт 6 арга хэмжээг нягтлан үзэж, цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн 2024 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ерөнхий гүйцэтгэл 96.67 хувьтай гэж дүгнэж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1396 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг үнэлгээний нэгдсэн системд 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөр баталгаажуулсан.	2024/01	100
4.	Арга хэмжээ 1.4. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, www.new.unelgee.gov.mn цахим хаягт оруулсан байх.	Гарсан тайлан, хяналт-шинжилгээ үнэлгээний дүгнэлт зөвлөмжийн хамт холбогдох байгууллагад хүргүүлсэн албан бичгийн тоо	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 06 сарын 27-ны өдрийн 01/1355 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2024 он гарснаас хойш цахим системд нийт 5 удаа	1 3	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн арга хэмжээний биелэлтэд эцсийн хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 12 сарын 31-ний өдрийн 03/1400 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эхний удаагийн хэрэгжилтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын monitoring@ags.gov.mn хаягт албаны хаягаар 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр илгээсэн.	2025/01 2025/12	100%

		тоо, системд оруулсан тоо	тайлагнан ажилласан.		Түүнчлэн Засгийн газрын 2025 он 43 дугаар тогтоолоор уг тайланг цаашид улиралд 1 удаа илгээхээр байна.		
5.	Арга хэмжээ 1.5. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, www.new.unelgee.gov.mn цахим хаягт оруулсан байх.	Гарсан тайлан, хяналт-шинжилгээ үнэлгээний дүгнэлт зөвлөмжийн хамт холбогдох байгууллагад хүргүүлсэн албан бичгийн тоо, системд оруулсан тоо	2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 01/1217 дугаартай албан бичгээр Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлсэн. Мөн 2024 он гарснаас хойш цахим системээр Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө нээгдээгүй болно.	1 3	Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн эцсийн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1385 дугаартай албан бичгээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Мөн 2025 он гарснаас хойш цахим системээр Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг 1 удаа тайлагнасан. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын дагуу хагас жил тутам 1 удаа тайлагнахаар байна. Сар бүр цахим системээр тайлагнах шаардлагагүй болсон.	2025/01-2025/12	100%
6.	Арга хэмжээ 1.6. Яамны ил тод байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж гаргасан тайлангийн хамтаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байх, www.unelgee.gov.mn цахим хаягт оруулсныг хянаж, баталгаажуулахад бэлтгэсэн байх.	Засгийн газрын үнэлгээний системд тайлагнасан байдал, хүргүүлсэн албан бичгийн тоо	Яамны 2023 оны жилийн эцсийн байдлаар ил тод байдалд хяналт-шинжилгээ хийж, 2024.02.28-ны 03/259 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Цахим системд тайлагнасан.	1 1	Яамны 2024 оны жилийн эцсийн байдлаар ил тод байдалд хяналт-шинжилгээ хийж, 99.14 хувиар үнэлгээ хийж, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1357 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт биелэлтийг хүргүүлсэн. Мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд 2025.01.03-ны өдөр тайлагнасан.	2025/03	100%

Зорилт 2. Газрын гүйцэтгэлийн зорилт 1. Яам болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, төсвийн хөрөнгө орлого зарлага, төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт, дотоод аудит явуулах, үр дүнд нь үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бууруулах талаар зөвлөмж гаргана.

7.	Арга хэмжээ 2.1. Яам агентлаг, салбарын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдэд хариуцсан ажлын чиглэлээр сургалт зохион байгуулна.	Гарсан тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн баримт бичгийн тоо	2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10 цагт ZOOM-р зохион байгуулсан. Харьяа салбарын байгууллагуудад зохион байгуулсан.	1	Сүүлийн хагас жилд төлөвлөсөн.	2025/12	Хугацаа болоогүй
8.	Арга хэмжээ 2.2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг бэлтгэн Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлнэ.	Гарсан тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн баримт бичгийн тоо	2024.02.29-ний 03/414 дугаар албан бичгээр 2023 оны тайланг хүргүүлсэн.	1	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 03/511 дугаартай албан бичгээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт "Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан"-ыг хүргүүлсэн. Яамны файлын санд хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг оруулж нэгжүүдэд зөвлөмж, дүгнэлттэй танилцах тухай мэдэгдсэн.	2025/01	100%
9.	Арга хэмжээ 2.3. Төсвийн тухай хуулийн 1 хавсралтын хэрэгжилтийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст хүлээлгэн өгөх	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст хүлээлгэн өгсөн тайлан	2024.08.21-нд Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст албаны мэйлээр илгээсэн.	1	Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтын дагуу бэлтгэсэн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт зөвлөмжийн хамтаар 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их хурлын Төсвийн зарлагын дэд хороонд хүргүүлсэн. Түүнчлэн Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс төсвийн гүйцэтгэлийн тайлан, бусад нэгжүүд Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтын дагуу тайлан нэгтгэлийг гаргаж өгсөн болно.	2025/03 2025/08	100%
Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд							
10.	Арга хэмжээ 3.1. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг холбогдох албан хаагчидтай хамтран боловсруулах, төлөвлөгөөний өөрт	Боловсруулсан төлөвлөгөө, тайлангийн тоо	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг холбогдох албан хаагчидтай хамтран боловсруулсан.	Төлөвлөгөө-1 Тайлан 1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг албан хаагчдын хамт боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдөрт багтаан батлуулж, хувийг Төрийн захиргааны удирдлагын газарт хүлээлгэн өгсөн. Нэгжийн 1 дүгээр улирлын биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөрт багтаан Төрийн захиргааны удирдлагын	2025/01 - 2025/06	100%

	холбогдох хэсгийн хэрэгжилтийг тайлагнах;		Мөн тухай бүр тайлагнасан.		газарт хүлээлгэн өгсөн. Сар бүрийн тайланг тухай бүр тайлагнасан.		
--	---	--	----------------------------	--	---	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-н контрактын биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хүргүүлэх.	Хүргүүлсэн тайлан	-	1	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-н контрактын гэрээний биелэлтийг 15 оноогоор үнэлгээ хийж 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 02/856 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	2025.05.17	100%
2.	Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны сэтгэл ханамжын судалгаа, Төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг байгууллагын хэмжээнд зохион байгуулж Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт тайлагнах. Эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэхтэй холбоотой сургалт, фокус бүлгийн ярилцлагад хамрагдах.	Хүргүүлсэн тайлан, албан бичиг Сургалтад хамрагдах.	-	1	2 судалгаанд яамны албан хаагчдыг хамруулсан. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаатай холбоотойгоор яамны нэгжийн дарга нарыг оролцуулан Удирдлагын зөвлөлийн хурал зохион байгуулж судалгаанд хамрагдсан. Түүнчлэн Удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл, судалгаанд хамрагдсан тайланг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 02/900 дугаар албан бичгээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Мөн Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Хяналт, үнэлгээний үндэсний хорооноос зохион байгуулсан байгууллагын эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэх аргачлал сэдэвт сургалтад хамрагдсан. Яамны бүхий л нэгжүүд уг асуудлыг хариуцан ажиллах шаардлагатай болохыг сургалтаар олж мэдсэн. Үүнд ТЗУГ, СБТГ, СХГ, ХШУДАГ болон бусад нэгж гэх байдлаар эрсдэлийг салбар бүрт нь хариуцуулж ажиллах нь зүйтэй байна.	2025.04.18-ны дотор	100%
3.	Үндэсний аудитын газраас ирсэн бичгүүдийн дагуу арга хэмжээ авч төлөвлөгөө бэлтгэн хүргүүлэх.	Хүргүүлсэн албан бичиг	-	1	Үндэсний аудитын газарт Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бэлтгэн 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 02/901 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн	Тухай бүр	100%

					гүйцэтгэлд хийсэн аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахад харьяа салбар байгууллага, яамны нэгжүүдээс 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 02/1087 дугаартай албан бичгээр төлөвлөгөөний төсөлд оруулах саналуудыг нэгтгэж Үндэсний аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/1290 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.		
4.	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт Салбарын хөгжлийн үзүүлэлтийн тайланг бэлтгэн илгээх.	Хүргүүлсэн тайлан	-	1	2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 03/325 дугаартай албан бичгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны "Салбарын хөгжлийн үзүүлэлт"-ийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмжийн хамтаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Салбарын хөгжлийн үзүүлэлт нийт 9 үзүүлэлтийн хүрээнд дүгнэсэн бөгөөд үнэлгээний дундаж оноо 96,6 хувиар тавьсан байна. Түүнчлэн шинээр батлагдсан Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолд Салбарын хөгжлийн үзүүлэлтийн тайланг гаргах эрх зүйн зохицуулалт ХШҮДАГ-т байдаггүй тул цаашид хамаарах нэгжид тайланг нэгтгэх үүрэг даалгавар өгөх нь зүйтэй байна.	Тухай бүр	100%


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Худалдан авах ажиллагааны сургалтад сурч төгссөн байна.	Сертификат	2024.3.18-19-нд Удирдлагын академид "Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах арга зүй" сэдэвт сургалтаар сертификат, Хувиараа гарааны	1	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь удирдлагаас гадна 5 хүний бүрэлдэхүүнтэй байхаар бүтэц зохион байгуулалтаар тусгагдсан боловч одоогоор тус нэгжид орон тооны дутагдал үүссэн. Иймээс Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох шалгалтад хамрагдаж амжаагүй. Харин Засгийн газрын Хяналт	2025/06 - 2025/12	0%

			бизнес эрхлэгчдийн уралдаанд төслийн уралдаанд оролцож бичсэн төслөөр шагналт байрт шалгарсан. Сургалтын сертификат авсан.		хэрэгжүүлэх газар, Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр хамтран зохион байгуулсан "Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам танилцуулах сургалт"-д Стратеги бодлого төлөвлөлтийн нэгжийн албан хаагчийн хамтаар хамрагдаж №20250148 дугаартай сертификат гардан авсан.		
2.	Арга хэмжээ 2. Байгууллагаас зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд хамрагдах.	Хамрагдсан хурал, зөвлөгөөний тоо	-	1	ХШҮДАГ нь нэгжийн даргагүй ажиллаж байх тул сайд, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаан болон бусад нэгжүүдээс зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд тухай бүр нэгжийг төлөөлөн оролцож байна. Түүнчлэн Засгийн газар, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Сангийн яам, Үндэсний аудитын газар гэх мэт байгууллагуудаас зохион байгуулсан уулзалт, сургалтуудад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамыг төлөөлөн тухай бүр хамрагдаж байна.	2024/01 - 2024/06	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

..........А.ТҮВШИНЗАЯА 2025.06.05.